

**АРВИЖИХ ХК-ИЙН 2025 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

Огноо:	2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цаг
Хуралдсан газар:	БЗД, 25-р хороо, Маргад хотхон 82-9 тоот
Хурлын ирц:	95.18 хувь
Саналын эрхийн тоо:	53,666 ширхэг энгийн хувьцаа
Хурлын дарга:	Д.Баатар
Хурлын нарийн бичгийн дарга:	Б.Эрдэнэбат
Тооллогын комиссын гишүүд:	Д.Туруунаа Б.Энхбат

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;
3. Ноогдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
5. Их хэмжээний хэлцэл хийх тухай;

Ирцийн танилцуулга:

Арвижих ХК-ийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг Тооллогын комисс Д.Туруунаа танилцуулав: Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд 53,666 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигч оролцож байгаагийн 1 хувьцаа эзэмшигч брокерийн компаниар дамжуулан урьдчлан саналаа өгч бусад хувьцаа эзэмшигч биетээр оролцож байна. Нийт компанийн саналын эрх бүхий 56,381 ширхэг энгийн хувьцааны 95.18 хувьтай тэнцэж байгаа тул өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц хүчин төгөлдөр бүрдсэн болохыг мэдэгдэж байна.

Хурлын дарга Д.Баатар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулав.

Сайн байцгаана уу, 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа ирсэн та бүхэндээ баярлалаа. Бид өнөөдрийн хурлаар 5 асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргана. Өмнө танилцуулсан хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудал бүр дээр санал солилцож, саналын хуудсаар саналаа өгнө.

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

Хурлын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэбат: 2024 онд үйл ажиллагаа тогтвортой явагдаагүй харин бид хөрөнгө оруулалт, хийгдэх төслийн бизнес төлөвлөгөөний ажил дээр ажилласан. Манай компани хүнсний ногоо хадгалах зоорийн үйл ажиллагаа эрхлэдэг энэ чиглэлээр төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Санхүүгийн хувьд үйл ажиллагаа эрхлэх хөрөнгө мөнгө одоогоор байхгүй гарч байгаа зардлыг хувь хүнээс гаргаж төлж байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Содбаяр: Төслийн материалтай танилцаж үзлээ. Жил болгон бидний ажил хойшилж байна, 2024 онд хурдтай ажилламаар байна. Хөрөнгө оруулалт, зээл авах асуудал хүнд байгаач зоорийн газрыг ашиглаж хөрөнгө оруулалт татмаар санагдаж байна.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт;

Хурлын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэбат: Үйл ажиллагааны тогтмол зардалтай алдагдалтай тайлан гарсан байгаа. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлангийн үлдэгдэл болон гарсан зардлуудыг баталгаажуулж дүгнэлт гаргасан байгаа. Тайлангаар гарсан зардалд Хувьцаа эзэмшигчдийн хурал явуулахад гарсан зардал, хөрөнгийн бирж болон үнэт цаасны хадгамжийн төвийн жилийн хураамж үйлчилгээний зардал гэхчлэн зардлууд гарсан байгаа. Зардлын эх үүсвэрийг зээлээр шийдвэрлэж байна.

Хэлэлцэх асуудал 3: Ноогдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;

Хурлын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэбат: 2024 оны санхүүгийн тайланг үндэслэн ногдол ашиг тараахгүй ТУЗ-ийн шийдвэр гаргаж СЗХ болон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан мэдээлсэн байгаа.

Хэлэлцэх асуудал 4: Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;

Хурлын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэбат: Компанийн үйл ажиллагааны чиглэл дээр үргэлжлүүлэн 2025 онд төсөл хэрэгжүүлэх бөгөөд хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхийн тулд их хэмжээний хэлэлцэх хийх талаар хувьцаа эзэмшигчдээс санал авах үүднээс хуралд асуудал болгон оруулсан байгаа.

Хэлэлцэх асуудал 5: Их хэмжээний хэлцэл хийх тухай;

Компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүд, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай бусад этгээдээс хөрөнгө оруулалт, зээл болон санхүүжилт татан төвлөрүүлэх шаардлагатай байна. Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1-д Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн

үнэтэй хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл; 87.2-д компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалтыг их хэмжээний хэлцэлд тооцно гэж заасан байна.

Бид компанийн эзэмшлийн Нийслэлийн засаг даргын 2016 оны А/308 тоот шийдвэрийн дагуу Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт олгогдсон 51134 м2 талбай бүхий газар дээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах, зээлийн барьцаанд тавих, энэхүү тогтоолд дурдсан аливаа асуудлаар бусад этгээдтэй их хэмжээний болон бусад ямарваа гэрээ хэлцэл байгуулах, гэрээ хэлцлийн нөхцлийг тохиролцоход дээрх саналыг хурлаар хэлэлцүүлэхээр дахин оруулж ирж байна.

Хэлэлцэж буй асуудлуудтай холбоотой асуулт, хариулт

Хувьцаа эзэмшигч Б.Содбаяр: Асуулт гэхээсээ илүү их хэмжээний хэлцэлтэй санал нэг байна. Яагаад гэвэл тус газар дээр төсөл хэрэгжүүлэхэд багагүй хэмжээний хөрөнгө шаардлагатай болно, төслөө хөдөлгөхийн тулд хөрөнгө оруулагч, хамтран сонирхолтой байгууллага хүмүүстэй уулзахад хамтран ажиллах нөхцөл зайлшгүй яригдах асуудал болно. Тэгэхээр компанийн хувьцаа эзэмшигчийн хувьд компаниа үр ашигтай явуулах, үр ашиг хүртэх нь бидний зорилго тул энэ асуулыг зөв зүйтэй гэж харж байна.

Хурлын нарийн бичгийн дарга Б.Эрдэнэбат: Их хэмжээний хэлцлийг дэмжиж саналаа хэлсэн таньд баярлалаа. За ингээд саналаа хураацгаая.

Санал хураалтын цаг эхэлж, хувьцаа эзэмшигчид саналаа өгөв. Үүний дараа Тооллогын комисс Б.Дэмбэрэл хурлаар хэлэлцсэн асуудал бүрээр хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчид хэлэлцсэн асуудал дор дурдсан байдлаар саналаа өгөв. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувь нь зөвшөөрсөн, 0 хувь нь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувь нь зөвшөөрсөн, 0 хувь нь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн;
3. Ноогдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувь нь зөвшөөрсөн, 0 хувь нь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн

4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувь нь зөвшөөрсөн, 0 хувь нь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн;
5. Их хэмжээний хэлцэл хийх тухай асуудлын хувьд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувь нь зөвшөөрсөн, 0 хувь татгалзсан, 0 хувь нь түдгэлзсэн

Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан батлах тухай
Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дугаар ХЭХТ25/02 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:
 1. Компанийн 2024 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тухай ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагын гаргасан тайланг хангалттай гэж үзсүгэй.
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт:
Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дугаар ХЭХТ25/03 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:
 1. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.
3. Ноогдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах:
Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тооллогын комиссын дугаар ХЭХТ25/04 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:
 1. Компани нь 2024 онд орлого олох үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажилласан нь санхүүгийн тайланд тусгагдсанг үндэслэн гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хангалттай гэж үзсүгэй.
4. Компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах:
Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 62 дугаар зүйлийн 1.7-р заалт, 75 дугаар зүйл 4-р заалт, 81 дүгээр зүйлийн 2-р заалт болон Арвижих ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын тооллогын комиссын дугаар ХЭХТ25/05 шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:
 1. 2025 онд компанийн бизнесийн үйл ажиллагааг сэргээх боломж бололцоог судалж боловсруулсан төлөвлөгөө дагуу ажиллахыг ТУЗ-д даалгасугай.
5. Их хэмжээний хэлцэл хийх тухай:
“Арвижих” Хувьцаат компани (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оны 04 сарын 30-ны өдрийн хурлын тооллогын комиссын ХЭХТ25/06 дугаар шийдвэр,

хурлын протокол, Иргэний хуулийн 62 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 83 дугаар зүйлийн 83.8 дахь хэсэг, 87 дугаар зүйл, Компанийн дүрмийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2025 онд хэрэгжүүлэх, төсөл, үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт №1-аар баталсугай.
2. Компанийн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүд, үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай бусад этгээдээс хөрөнгө оруулалт, зээл болон санхүүжилт татан төвлөрүүлэх, Компанийн эзэмшлийн Нийслэлийн засаг даргын 2016 оны А/308 тоот шийдвэрийн дагуу Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт олгогдсон 51134 м² талбай бүхий газар дээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтран ажиллах, зээлийн барьцаанд тавих, энэхүү тогтоолд дурдсан аливаа асуудлаар бусад этгээдтэй их хэмжээний болон бусад ямарваа гэрээ хэлцэл байгуулах, гэрээ хэлцлийн нөхцлийг тохиролцох, тэдгээрт Компанийг төлөөлж гарын үсэг зурж баталгаажуулах, нотариатаар гэрчлүүлэх зэрэг энэхүү шийдвэрт дурдсан зорилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой, шаардлагатай, тохиромжтой, зөв гэж үзсэн аливаа үйлдэл хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Содбаяр/-д итгэмжлэн олгосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслүүдийг танилцуулснаар хурал 16 цаг 15 минутад хурал өндөрлөж хурлын дарга Д.Баатар хурал хааж үг хэлэв.

Хурлын проткол хөтөлсөн:

Б.Энхбат

Хянасан ТУЗ-ын дарга:

Д.Баатар

